

Цацраг идэвхт хаядал бол тоглоом биш!!!

Ураны уурхай, АЦС-аас гарах хаягдал дахь цацраг идэвхт бодисууд 20'000-4'000'000'000 жилийн турш хорт цацраг ялгаруулсаар байдаг. Ийм урт хугацаанд аюулт хор ялгаруулах цөмийн урвалыг зогсоох “Тоормосыг” дэлхий дахин олж чадаагүй боловч АЦС гэсэн хурдан галт тэргэнд суусаар... Урд нь үүссэн цөмийн хаягдлаа устгаж чадсан улс дэлхийд ганц ч байхгүй байна.

Монгол улс АЦС ажиллуулж “өндөр түвшний” цөмийн хаягдалтай нэгэнт болчихвол цацраг идэвхт бодисыг хүссэн ч хүсээгүй ч нутагтаа булж хадгалах л болно (заавал гадных биш). Байгаль, хүн ам цацраг идэвхтээр хордоно...

Түүнчлэн дэлхийд анх удаа Олон Улсын Цөмийн Хаягдлын Байгууламж Монгол улсад барих тухай нууц гэрээ хийгдэж байгаа гэсэн мэдээлэл нь оргүй зүйл биш болох нь ажиглагдсаар байна.



Эх нутгаа цөмийн жорлон болгох уу?

Цөмийн хорт хаягдлаас урган гарч болох улс төр, эдийн засгийн эрсдлүүд:

1. Цөмийн хорт хаягдлыг дахин боловсруулж цөмийн зэвсэг хийдэг түүхий эдийг хялбар аргаар гаргаж авч болдог. Монгол улс цөмийн зэвсэг сонирхогч улс орнууд, террористуудын халдлагын бай улс болох эрсдэлтэй.
2. Монгол улс дэлхий дээр цөмийн хог хаягдлыг булшлагч улс орон гэсэн нэртэй болж жуулчид ирэхээ больж, экспортоор бараа таваараа гаргаж гадаадууд худалдахад авахаа больж эдийн засаг сүйрнэ.



Герман улс тэргүүлэн дэлхийн томоохон улсууд цөмийн эрчим хүчнээс татгалзан сэргээгдэх голлон бусад эрчим хүчийг хөгжүүлэн ашиглах шийдвэрийг засгийн газрын түвшиндээ гаргаж, Siemens тэргүүтэй компаниуд энэ чиглэлийн бизнесээ зосоохоо зарлаж эхлээд байна.



Бид нутагт маань цөмийн хаягдал булахын эсрэг зүрх сэтгэлээрээ холбогдон интернетээр нэгдэж, хувиасаа зардлаа гарган үүнийг хэвлэн тарааж буй юм. Facebook дэх бүлэг: <http://www.facebook.com/groups/bayarlalaa/>

Энэ хуудсыг багтаахын тулд эх сурвалжуудыг үл дурдан эмхэтгэсэн ба www.nuclearfreemongolia.com хаягаар интернет хуудас руу орж мэдээллийн бодит эх сурвалж, материалуудтай танилцах боломжтой.

Хуудсыг уралгүй, хаялгүйгээр гэр бүлийн гишүүд, найзууддаа уншуулан эх орныхоо төлөөх тайван тэмцэлд хувь нэмрээ оруулаарай. Та олируулан тараахыг хүсвэл эх файлыг дээрх интернет хуудаснаас татаж авч болно.



2011.09.24

-4-



МЭДЭЛЭГИЙН ХУУДАС




Та Монгол хүн бол уралгүй, хаялгүй, уншиж дуусга!!!

Тоормосгүй хурдан галт тэргэнд Монголчууд бүгдээрээ суух уу? Яагаад вэ? гэж үү? Яагаад гэдгийг та энэхүү хуудаснаас мэдэж сэрэмжлээрэй.


Цацраг идэвхт бодис гэж юу вэ?

Эдгээр нь задрах явцдаа маш хүчтэй нэвтлэх чадвартай цацраг туяа ялгаруулдаг химийн элементүүд юм. Атомын цахилгаан станцын түлш болох УРАН, шатаад үлдэх шаар нь маш хүчтэй цацраг идэвхт бодисууд агуулдаг.



Цацраг туяа хүний биед хэрхэн нөлөөлдөг вэ?

Хүний биеийг үл үзэгдэм нарийн зүү мэт нэвт сүлбэх явцдаа эсүүдийг маш нарийн түвшинд гэмтээж хавдар үүсгэдэг.



Ионжсон цацраг: Ураны атом задралдаа цацраг туяа ялгаруулдаг ба тэр нь хүний эд эсийг нэвтлэн, эсийн ДНХ-ийг гэмтээдэг ба ингэж гэмтсэн эс үржлээ удирдах чадваргүй болж замбараагүй үрждэг - ХОРТ ХАВДАР



Эхийн хэвлийд бойжиж буй үр хөврөлд цацраг туяа нөлөөлөхөд зулбах, эсвэл гаж хөгжилтэй хүүхдүүд төрдөг.

АЦС-ЫН ТУХАЙ БОДИТ БАРИМТУУД

Монгол улс Атомын Цахилгаан Станцтай болбол цахилгаан эрчим хүчний үнэ олон дахин хямдарна гэдэг бол худал!!!

АЦС-тай улсуудад цахилгаан станцуудын үйлдвэрлэж буй эрчим хүчний үнийг харьцуулан судлахад нүүрсний эрчим хүчнээс цөмийн эрчим хүч хямд байж чаддаггүй байна.

Зурагт 2010 онд Германы зах зээл дэх эрчим хүчний бодит үнийн харьцуулалт. 1кВт ЭХ: Нүүрс-12.1¢ ба АЦС-12.8¢




АЦС барих зардлыг л тооцвол ашигтай мэт боловч харин барьсан станцыг ажиллуулах, засвар үйлчилгээ, байгаль орчин, уран олборлолт, нөхөн сэргээлт, цөмийн хаягдлын хөргөлт, 500метрээс доош гүнд байгууламж барьж булшлах, хүмүүсийн эрүүл мэнд зэрэг бусад зүйлд зарцуулагдсан мөнгө нь эргээд атомын цахилгаан эрчим хүчний үнийг нүүрснээс ашиггүй хэмжээнд хүргэдэг байна.

Тэгвэл яагаад бусад улс атомын цахилгаан станц хэрэглэдэг вэ?

Учир нь тэдэнд өөрсдийн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц нүүрсний нөөц хомс болохоор, бас тэд Монгол шиг хэт цөөхөн хүн амтай биш болохоор юм. Монголд бол АЦС барих ийм шаардлага байхгүй, нүүрс хангалттай элбэг, харьцангуй хямд үнэтэйн дээр цаашид нар, салхи, биомассын болон бусад сэргээгдэх эрчим хүч хөгжүүлэн ашиглах боломж өндөртэй.

АЦС ажиллуулахад хүрэлцэх ус Монголд байгаа юу?



АЦС нь 1000 хэмээс өндөр халуун гаргаж, түүнийг нь далай, тэнгис, гол мөрний усаар хөргөдөг. Хөргөхөд агаарт их хэмжээний ус бүдүүн яндангаар ууршиж байдаг. Гэтэл Монголын нутаг цөлжиж байгаа нь улам хатна. Японы Фукушимад АЦС дэлбэрсэн шиг нөхцөл байдал үүсвэл хүрэлцэхүйц хэмжээний ус бий юу?

2011.08.28-нд Өмнөговь аймагт төвтэй 8 баллын хүчтэй газар хөдлөлт болов...

Ураны уурхайн тухай баримт мэдээлэл

АЦС-ын ердөө 20тн түлш бэлдэхэд 170тн ураны хүдэр олборлож 150тн нь цацраг идэвхт бодис бүхий буталсан чулуу, шороон уул овоо босож, агаарт уушгины рак үүсгэдэг цацраг идэвхт тоосонцор ихээр үүсэж, их хэмжээний ус цацраг идэвхтээр бохирлогдон, газрын хөрсөнд нэвчин бохирдуулдаг байна. 20тн түлш нь шатаж дуусаад асар их аюултай цөмийн хорт хаягдал болно.



АЦС болон Ураны олборлолтыг эсэргүүцэхгүйгээр зөвхөн хог хаягдлыг нь эсэргүүцнэ гэвэл усны цоргыг хаалгүйгээр шалан дээр гоожиж буй усыг шавхрахтай адил хог хаягдал урсан гарсаар л байх болно.

Тиймээс АЦС, Ураны уурхайг дэмжиж байгаа хүн бол цөмийн хог хаягдлыг нутагтаа хаяхыг ч мөн дэмжиж байгаа, байгаль орчноо сүйтгэхийг ч дэмжиж байгаа гэсэн үг юм!!!

Эрх баригч дарга нар маань “Монголд цөмийн хаягдал хаяулахгүй” хэмээн ярьж, зарлиг гаргаж буй хэдий ч Уран олборлох, АЦС барих талаар олон улстай идэвхтэй ярьж, гэрээ хэлэлцээрүүд хийсээр л байна. Гэтэл тэндээс гарах их хэмжээний хаягдлыг яах вэ? Удаан хугацаанд аюулгүй хадгалах байгууламжийг хэнээр ямар нөхцөлтэйгөөр барихаар гэж байгаа вэ?

Эсвэл тэд ард иргэдийн эсэргүүцлийг намжаах гэж худал ярьж байна уу?